

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймаг дахь Улсын халамжийн сан 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БУА-2022/146/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Булган аймаг
2022 он

Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр
Утас: 70342580 Цахим хаяг: ankhbayard@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 70342716 Цахим хаяг: enhtsoodolj@audit.gov.mn

Аудитор: Б.Пүрэвсүрэн
Утас: 70353717 Цахим хаяг: dalaivan.orkhon@gmail.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2-3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
3. Аудитын тайлан	8
3.1 Ерөнхий зүйл	8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	9
3.4 Материаллаг байдал	9
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	9
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	9
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	11
3.8 Аудитын гол асуудал	11
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	11
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	12
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	12
4. Аудитын илрүүлэлт.....	12
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	Error! Bookmark not defined.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХАА	Хөдөө аж ахуй

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ



БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхлагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-3259
E-mail: bulgan@audit.gov.mn

2022.02.24. № 37

танай _____ ны № _____ т

ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА
Н.БАТЖАРГАЛ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын Улсын төсвийн халамжийн сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын Улсын төсвийн халамжийн сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

D:\bichighereg\2022A4\toot

006020003

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

D:/bichighereg/2022A4toot

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
.	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ [2]+[3]	585,303.67	0
3101	Кассанд байгаа бэлэн мөнгө	0	0
3102	Банкинд байгаа бэлэн мөнгө/төгрөг/ [4]+[5]	585,303.67	0
310201	Банкинд байгаа бэлэн мөнгө/Улсын төсөв/	585,303.67	0
3.1.4.1	Банкинд байгаа бэлэн мөнгө/ОНТөсөв/	0	0
33	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН [1]+[6]	585,303.67	0
.	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	0	0
.	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН [13]+[14]	585,303.67	0
41	Богино хугацаат өр төлбөр [18]+[21]+[22]+[23]	2,763,000.00	0
4.1	Өглөг [18]+[21]+[22]+[23]	2,763,000.00	0
410101	Байгууллага хоорондын тооцоо УТ	1,504,480.00	0
410102	Байгууллага хоорондын тооцоо ОН	0	0
410301	Хувь хүнд өгөх улсын төсвийн өглөг	1,258,520.00	0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН [16]+[24]	2,763,000.00	0
41	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	0	0
41	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН [27]+[28]	2,763,000.00	0
510301	Өмнөх үеийн үр дүн	(1,078,642.45)	(2,177,696.33)
510302	Тайлант үеийн үр дүн	(1,099,053.88)	2,177,696.33
5103020002	Тайлант үеийн үр дүн орон нутаг	0	0
0	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН [30]+[31]+[32]+[33]	(2,177,696.33)	0
0	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ ӨМЧИЙН ДҮН [29]+[34]	585,303.67	0

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Мөр	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1303	ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО [2]+[3]	8,594,686,120.00	3,801,183,400.00
130301	Улсын төсвийн санхүүжилтийн орлого	8,594,686,120.00	3,801,183,400.00
130302	Орон нутгийн төсвийн санхүүжилтийн орлого	0	0
14	Бараа, үйлчилгээний орлого [5]+[6]+[7]+[8]	7,456,267.00	19,723.95
1401011	Улсын төсвийн хүүгийн орлого	7,456,267.00	19,723.95
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН [1]+[4]	8,602,142,387.00	3,801,203,123.95
2603	Төсөвт төвлөрүүлэх [16]+[17]	112,413,050.88	21,302,987.62
260301	Төсөвт төвлөрүүлэх улсын төсөв	112,413,050.88	21,302,987.62

Булган аймаг дахь Улсын халамжийн сан 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

260302	Төсөвт төвлөрүүлэх орон нутгийн төсөв	0	0
2701+2702	НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ [19]-с [39]-р мөр	8,488,419,640.00	3,776,371,690.00
2701010101	Халамжийн тэтгэврийн сангийн зарцуулалт	3,055,914,840.00	735,871,800.00
2701010102	Халамжийн тэтгэмжийн сангийн зарцуулалт	1,544,484,010.00	1,309,774,750.00
2701010103	Амжиргааг дэмжих мөнгөн тэтгэжийн зарцуулалт	843,370,830.00	813,738,400.00
2701021300	Онцгой тохиолдлын болон амжиргааг дэмжих мөнгөн тэтгэжийн зарцуулалт	0	0
2701010900	Ахмад настны нийгмийн хамгааллын тусламж, хөнгөлөлтийн зарцуулалт	338,501,250.00	179,662,000.00
2701011000	Ихэр хүүхдийн тэтгэмжийн зарцуулалт	14000000	-
2701010105	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тусламж, хөнгөлөлт	97,264,730.00	102,914,000.00
2701021701	Боловсролыг дэмжих үйлчилгээ	0	0
2701021702	Эрүүл мэндийг дэмжих үйлчилгээ	0	0
2701010104	Жирэмсэн нярай, хөхүүл хүүхэдтэй эхийн тэтгэмжийн зарцуулалт	16,930,870.00	0
2701023000	ОНОТүшгэлсэн халамжийн үйлчилгээний зарцуулалт	0	0
2701010106	Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний зарцуулалт	1,041,528,000.00	614,740,000.00
2701025	Туршилтын үйлчилгээ	0	0
2702010101	Алдарт эхийн одонгийн мөнгөний зарцуулалт	708,360,000.00	0
27020102	Ахмад дайчид алдар цолтон ахмад настанд олгох тэтгэмж хөнгөлөлт	59,114,000.00	0
2702010400	Насны хишиг	526,810,000.00	0
2701010700	Цалинтай ээж хөтөлбөрийн зардал	129,032,770.00	0
2701010800	Өрх толгойлсон эх,эцэг хөтөлбөрийн зардал	93,390,740.00	0
2701010108	Амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүдийн урамшуулал	19,717,600.00	19,670,740.00
2702026000	Цаатан иргэдийн мөнгөн тэтгэмж	0	0
.	Банкны шимтгэл [41]+[45]	2,408,750.00	1,350,750.00
.	Банкны шимтгэл УТ [42]+[43]+[44]..+[56]	2,408,750.00	1,350,750.00
.	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН [10]+[15]+[18]+[40]	8,603,241,440.88	3,799,025,427.62
.	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН [9]-[50]	-1,099,053.88	2,177,696.33

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Д/д	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 12 сарын 31-ээрх үлдэгдэл	0	0	(2,177,696.33)	(2,177,696.33)
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0	0	0	0
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0	0	0	0

5	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0	0	0	0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	0	0	0	0
7	Тайлант үеийн үр дүн	0	0	2,177,696.33	2,177,696.33
8	2021 оны 06 сарын 30-аарх үлдэгдэл	0	0	0	0

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Д/д	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1303	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО [2]+[3]	8,594,686,120.00	3,801,183,400.00
130301	Улсын төсвийн санхүүжилтийн орлого	8,594,686,120.00	3,801,183,400.00
130302	Орон нутгийн төсвийн санхүүжилтийн орлого	0	0
1401	Бараа, үйлчилгээний орлого [5]+[6]+[7]+[8]+[9]+[10]	16,754,017.00	5,058,223.95
1401011	Улсын төсвийн хүүгийн орлого	7,456,267.00	19,723.95
1401012	Улсын төсвийн бусад орлого		
1401021	Орон нутгийн төсвийн хүүгийн орлого	0	0
1401022	Орон нутгийн төсвийн бусад орлого	0	0
1401013	Улсын төсвийн буцаасан орлого	9,297,750.00	5,038,500.00
1401023	Улсын төсвийн бусад орлого	0	0
.	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ТӨВ [1]+[4]	8,611,440,137.00	3,806,241,623.95
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ [13]+[14]+[15]+[16]	0	0
2701+2702	НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ [18]+...+[38]	8,494,954,390.00	3,781,410,190.00
2701021100	Халамжийн тэтгэвэрийн сангийн зарцуулалт	3,059,163,310.00	735,953,090.00
2701021200	Халамжийн тэтгэмжийн сангийн зарцуулалт	1,545,841,300.00	1,311,364,220.00
2701010103	Амжиргааг дэмжих мөнгөн тэтгэжийн зарцуулалт	843,658,830.00	815,086,140.00
2701021500	Ахмад настны нийгмийн хамгааллын тусламж, хөнгөлөлтийн зарцуулалт	338,511,250.00	179,662,000.00
2701021505	Бусад хөнгөлөлт, тэтгэмжийн зардал	0	0
2701021604	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тусламж, хөнгөлөлт	97,414,730.00	103,994,000.00
2701022000	Жирэмсэн нярай, хөхүүл хүүхэдтэй эхийн тэтгэмжийн зарцуулалт	18,005,180.00	0.00
2701024000	Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний зарцуулалт	1,041,544,000.00	615,680,000.00
2701025	Туршилтын үйлчилгээ	0	0
2702010101	Алдарт эхийн одонгийн мөнгөний зарцуулалт	709,200,000.00	0
27020102	Ахмад дайчид алдар цолтон ахмад настанд олгох тэтгэмж хөнгөлөлт	59,114,000.00	0
2702010400	Насны хишгийн зардал	527,110,000.00	0
2701010700	Цалинтай ээж хөтөлбөрийн зардал	129,366,450.00	0

Булган аймаг дахь Улсын халамжийн сан 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2701010800	Өрх толгойлсон эх,эцэг хөтөлбөрийн зардал	95,070,740.00	0
2701011000	Ихэр хүүхдийн тэтгэмжийн зарцуулалт	14,000,000.00	0
2702020307	Үйл ажиллагааны зардал /судалгаа/	0	0
2702020308	Амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүдийн урамшуулал	16,954,600.00	19,670,740.00
2702026000	Цаатан иргэдийн мөнгөн тэтгэмж	0	0
.	Банкны шимтгэл [40]+[44]	2,408,750.00	1,350,750.00
.	Банкны шимтгэл УТ [41]+[42]+[43]	2,408,750.00	1,350,750.00
.	Өмнөх оны олгогдоогүй мөнгөний зарцуулалт [50]+[51]	5,135,810.00	2,763,000.00
4103011	Өмнөх оны олгогдоогүй мөнгөний зарцуулалт УТ	5,135,810.00	2,763,000.00
41030211	Өмнөх оны олгогдоогүй мөнгөний зарцуулалт ОНТөсөв	0	0
2603	Төсөвт төвлөрүүлэх [53]+[55]	112,413,050.88	21,302,987.62
260301	Төсөвт төвлөрүүлэх улсын төсөв	112,413,050.88	21,302,987.62
260302	Төсөвт төвлөрүүлэх орон нутгийн төсөв	0	0
2701015000	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН [12]+[17]+[39]+[49]+[52]+[61]-[62]+[63]-[64]	8,614,912,000.88	3,806,826,927.62
.	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ [11]-[56]	-3,471,863.88	-585,303.67
.	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ [60]-[59]	(3,471,863.88)	-585,303.67
.	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,057,167.55	585,303.67
.	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	585,303.67	0.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

	Сангийн орлого	Төлөвлөгөө	Тайлант оны гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	0	585,303.67	0	0
2	Сангийн үйл ажиллагааны зардал [3]+[4]+[5]+[6]+[7]+[8]+[9]+[10]+[11]+[12]	3,801,183,400.00	3,780,485,440.00	20,697,960.0	99.46
3	Алдарт эхийн одонгийн мөнгө	0	0	0.0	0.0
4	Алдар цолтой ахмад настанд үзүүлсэн тэтгэмж тусламж, хөнгөлөлт	0	0	0.0	0.0
5	Насны хишиг	0	0	0.0	0.0
6	Халамжийн сан	0	0	0.0	0.0
7	Жирэмсэн болон нярай хөхүүл хүүхэдтэй эхэд олгосон тусламж	0	0	0.0	0.0
8	Олон нийтийн оролцоонд түншилсэн халамжийн үйлчилгээ	0	0	0.0	1.0
9	Хүнс тэжээл нийгмийн халамжийн хөтөлбөрийн зардал	615,600,000.00	614,740,000.00	860,000.0	99.86
10	Банкны шимтгэл	1,800,000.00	1,350,750.00	449,250.0	75.04
11	Амьжиргааг дэмжих зөвлөлийн урамшуулал	28,127,000.00	22,433,740.00	5,693,260.0	79.76

14	Ахмад настанд үзүүлэх хөнгөлөлтийн зардал	179,664,000.00	179,662,000.00	2,000.0	100.00
15	Халамжийн тэтгэвэрийн сангийн зарцуулалт	745,000,000.00	735,871,800.00	9,128,200.0	98.77
16	Халамжийн тэтгэмжийн сангийн зарцуулалт	1,310,021,000.00	1,309,774,750.00	246,250.0	99.98
17	Онцгой тохиолдлын болон амжиргааг дэмжих мөнгөн тэтгэжийн зарцуулалт	814,569,400.00	813,738,400.00	831,000.0	99.90
18	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тусламж, хөнгөлөлт	106,402,000.00	102,914,000.00	3,488,000.0	96.72
20	УЛСЫН ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТ	3,801,183,400.00	3,801,183,400.00	0.0	100.00
21	Тохируулгын дүн [1]+[11]-[2]-[15]	0	20,112,656.33	0	0

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Булган аймгийн улсын төсвийн халамжийн сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн санхүүгийн тайлагнал, бүртгэл хөтлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь “Бейкер Тилли Далайван аудит” ХХК-ийн аудитор Б.Пүрэвсүрэн гүйцэтгэж, эхний шатны хяналтыг ахлах аудитор, захирал Д.Мягмарсүрэн хэрэгжүүлж, 2 болон 3-р шатны хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, Орхон аймгийн төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Булган аймгийн улсын төсвийн халамжийн сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 21-ны өдрийн ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Булган аймгийн улсын төсвийн халамжийн сан нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай, Нийгмийн халамжийн тухай хууль, тогтоомжийн биелэлтийг хангуулан, төрийн хууль, ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, үйлчлүүлэгчдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдах таатай нөхцөлийг бүрдүүлэх, төрийн үйлчилгээг иргэдэд чанартай, хүртээмжтэй, шуурхай хүргэх үйл ажиллагаа эрхэлдэг.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил

гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллагад дотоод чанарын баталгаажуулалт, статистик хариуцсан ахлах ажилтан ажилладаг хэдий ч тухайн ажилтан чиг үүргээ хэрэгжүүлснээр тодорхой үр дүн гарсан эсэх нь тодорхойгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Булган аймгийн улсын төсвийн халамжийн сан нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 650,600.0 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 6,506.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 4,554.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Булган аймгийн улсын төсвийн халамжийн сан нь 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн тэг болсон цахим хэлбэрт шилжин сангийн яамнаас шууд иргэдийн дансанд мөнгөн шилжин ордог болж байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	585.3	0.0	(585.3)
Нийт хөрөнгө	585.3	0.0	(585.3)
Өр төлбөр	2,763.0	0.0	(2,763.0)
Тайлант үеийн үр дүн	(2,177.7)	0.0	2,177.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	585.3	0.0	(585.3)

Тайлант хугацаанд авлага өглөгийн үлдэгдэл үүсгээгүй ажилласан байна.

2020 онд Амьжиргааг дэмжих зөвлөлийн урамшууллын өглөг болох 2,763.0 төгрөгийн өглөгөөс ХХОАТ болох 1,504.5 төгрөг болон хувь хүнд олгох 1,258.5 төгрөгийн өглөгийг барагдуулсан ба нэмж өглөг тусгаагүй болно.

Бараа үйлчилгээг олон нийтэд хүргэсэн үед арилжааны орлогыг хүлээн зөвшөөрсөн болно. Тухайн санхүүгийн жилд :

- Улсын төсвөөс санхүүжилтийн орлого 3 801 .2 мянган төгрөг
- Улсын төсвийн санхүүжилтийн хүүгийн орлого 19.7 мянган төгрөг
- Буцаасан орлого 5 058,2 мянган төгрөгийг бүртгэж тайлагнасан байна.

Нягтлан бодох бүртгэлийн зардлыг гүйцэтгэлийг харуулбал:

- Халамжийн тэтгэвэр 735,953.1 мянган төгрөг
- Нөхцөлт мөнгөн тэтгэмж 1,311,364.2 мянган төгрөг
- Амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж 815,086.1 мянган төгрөг
- Хүнс тэжээлийн дэмжлэг тусламжаа 615,680.0 мянган төгрөг
- Ахмад настанд үзүүлсэн тусламж 179,662.0 мянган төгрөг
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлсэн тусламж 103,994.0 мянган төгрөг
- Амьжиргааг дэмжих зөвлөлийн урамшуулал 19,670.7 мянган төгрөг
- Банкны хураамж 1,350.7 мянган төгрөг тус тус зарцуулсан байна.

Булган аймгийн улсын төсвийн халамжийн сангийн санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт орлого өмнөх оноос 4,800,939.3 мянган төгрөгөөр буюу 44.2 хувиар, нийт зардал өмнөх оноос 4,804,216.0 мянган төгрөгөөр буюу 44.1 хувиар тус тус буурсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Булган аймгийн улсын төсвийн халамжийн сан нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 3,801,183.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 3,801,183.4 мянган төгрөгөөр тооцож, төлөвлөн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 3,801,183.4 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 3,801,183.4 мянган төгрөгийг улсын төсвөөс, бараа үйлчилгээний орлого 5,058.2 мянган төгрөг, урсгал үйл ажиллагаанд 3,784,938.6 мянган төгрөгийг зарцуулан 21,302.9 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн.

Нийт зарцуулсан 3,784,938.6 мянган төгрөг ба Хүнс тэжээл нийгмийн халамжийн хөтөлбөрийн зардлаас 860.0 мянган төгрөг, амьжиргааг дэмжих зөвлөлийн урамшууллын зардлаас 5,693.3 мянган төгрөг, халамжийн тэтгэврийн сангийн зарцуулалтын зардлаас 9,128.2 мянган төгрөг, халамжийн тэтгэмжийн сангийн зарцуулалтын зардлаас 246.2 мянган төгрөг, онцгой тохиолдлын болон амьжиргаа дэмжих мөнгөн тэтгэмжийн зарцуулалтаас 831.0 мянган төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэний тусламж, хөнгөлөлтөөс 3,488.0 мянган төгрөг, банкны шимтгэлийн зардлаас 449.2 мянган төгрөгийн зардлаас тус тус хэмнэсэн байна. Үүний шалтгаан нь Халамжийн тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж, амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмжийн үйлчилгээ е халамжид шилжсэнтэй холбоотой төсвийг

хасаж тооцсон ба онцгой тохиолдлын тэтгэмжийг олголтын файлын дагуу санхүүжилтийг захиалан авсан. Цар тахалтай холбоотой зарим нэг үйлчилгээнүүд зогссоноос шалтгаалан ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэний тусламж хөнгөлөлтийн зардал өмнөх онуудаас бага гарсан үзүүлэлттэй байна.

2021 онд төсвийн тухай хуулийн дагуу нийгмийн халамж, гэр бүлийн хөгжлийг дэмжих арга хэмжээнд зориулан батлагдсан хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж, төсвийн хуулийг чанд биелүүлж, төсвийн гүйцэтгэлийг хангаж, санхүүгийн сахилга баттай ажилласан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тухайн байгууллагын сангийн үйл ажиллагаанд нэмэлт санхүүжилтийн данс байхгүй болно.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд ковид-19 халдварт цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудитын хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно. Мөн тухайн байгууллага нь цахим хэлбэрт шилжин сангийн яамнаас шууд иргэдийн дансанд мөнгөн шилжин ордог болно.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь шилэн дансны цахим хуудсанд тогтмол болон тухай бүр мэдээлэх төсөв/гүйцэтгэлийн чиглэлийн 52 мэдээлэл, хөрөнгө оруулалт, тендер худалдан авалтын 39 мэдээлэл, бусад 5 төрлийн 58 мэдээ, мэдээллийг цаг хугацаанд нь бүрэн

мэдээлсэн, хугацаа хоцроосон байхгүй, мэдээлэх хугацаа нь болоогүй 2 мэдээлэл байна. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн мэдээллийг хуулийн хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж, зөрчил албан шаардлага акт аваагүй байна.


3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал


Балансын дараах үйл явдал болон бусад чухал асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар тухайн байгууллагад алдаа зөрчил илрээгүй болно.

АУДИТЫН ТАЙЛАНГ

БЭЛТГЭСЭН:
“БЕЙКЕР ТИЛЛИ ДАЛАЙВАН АУДИТ” ХХК-ИЙН ОРХОН АЙМАГ ДАХЬ САЛБАРЫН
АУДИТОР:  Б.ПҮРЭВСҮРЭН

ХЯНАСАН:
ЧАНАРЫН ХЯНАЛТЫН МЕНЕЖЕР, ЗАХИРАЛ:  Д.МЯГМАРСҮРЭН

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:
БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
АУДИТЫН МЕНЕЖЕР:  Ж.ЭНХЦООДОЛ

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:
БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Д.АНХБАЯР

